

Сөүлийн Их Сургуулийн Эмнэлгийг сонгон үйлчлүүлсэнд баярлалаа.

Та бүхнийг тав тухтай орчинд чанарын өндөр түвшний эрүүл мэндийн үйлчилгээгээр хангахын тулд бүхий л нөхцөл боломж, мэдлэг туршлагаа дайчлан ажиллах болно.

## Эрүүл амьдралын төлөө Сөүлийн Их Сургуулийн Эмнэлэгтэй хамтдаа



## Байршил & Холбоо барих



**Төв эмнэлгийн хоёр давхарт Олон Улсын Эмчилгээний Төв байрлаж байна.**

101 Тэхаг-ру, Жунру-гү, Сөүл, Кореа 03080

**Метро :** Хэхуа буудал (Метроны 4-р шугам) 3-р гарц

**Нисэх онгоцны буудал :** Автобусны зогсоол 5B, 12A  
Инчон олон улсын нисэх онгоцны буудлаас 6011 дугаарын автобусанд сууж,  
Чангёнгүн буудалд буух

### Холбоо барих

Ажлын цаг Даваа.- Баасан. 9:00-17:30  
Утас: 82-2-2072-0505  
Факс: 82-2-2072-0785 (24/7)

Яаралтай дуудлага : 82-10-8831-2890(24/7)

Имэйл Хаяг	Англи	international@snuh.org
	Араб	snuhuae@ihcworks.org
	Монгол	snuhmongolia@ihcworks.org
	Орос	snuhrussian@ihcworks.org
	Хятад	snuhchinese@ihcworks.org

[www.snuh.org/english](http://www.snuh.org/english)  
<http://blog.naver.com/snuhinternational>

## Шилдэг эмчилгээг Сөүлийн Их Сургуулийн Эмнэлгээс

# Олон Улсын Эмчилгээний Төв

## Сөүлийн Их Сургуулийн Эмнэлэг



## Сөүлийн Их Сургуулийн Эмнэлгийн Олон Улсын Эмчилгээний Төвд тавтай морилно уу

### Олон Улсын Эмчилгээний төв

Сөүлийн Их Сургуулийн Эмнэлэг нь Солонгос улсдаа төдийгүй дэлхийд шилдэгт тооцогддог бөгөөд 1999 оноос эхлэн Олон Улсын Эмчилгээний төвөө нээн гадаад өвчтөнүүдэд чиглэсэн чанартай эмчилгээ үйлчилгээг хүргэхийн тулд хичээнгүйлэн ажиллаж байна. Олон жилийн туршлагад тулгуурласан мэргэжлийн өндөр түвшний эрүүл мэндийн эмчилгээ үйлчилгээг үзүүлэхээс гадна өргөн цар хүрээтэй клиникийн судалгаа шинжилгээний ажлуудыг тасралтгүй явуулан эмнэлгийн нэр хүндээ өндөрт авч явж байна.

Цаашид ч дэлхийн хамгийн сүүлийн үеийн эмчилгээний арга технологид суурилсан, чанарын өндөр түвшний эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэхийн төлөө бүхий л хүч чадлаа дайчлан ажиллах болно.





# Сөүлийн Их Сургуулийн Эмнэлгийн давуу тал



## Солонгос улсын хамгийн анхны тэргүүлэх зэргийн улсын эмнэлэг

- Солонгосын анагаахын салбарын шилдэг боловсон хүчинтэй
- Солонгосын анагаах ухааны хөгжил дэвшилийг тодорхойлогч
- Солонгосын төрийн дээд албан хаагчдыг эмчлэх албан ёсны эрхтэй.



## Мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн хүний нөөц

- Солонгосын шилдэг анагаах ухааны их сургууль.
- Дэлхийд нэр хүндтэй олон эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүдийг бэлтгэн гаргасан.
- Жилд 2000 гаруй эрдэм шинжилгээний ажлыг SCI(Sciences Citation Index)-д хэвлэн нийтлүүлдэг.



## Солонгосын хамгийн баталгаатай, итгэмжлэгдсэн эмнэлэг

- Солонгосын эрүүл мэндийн мэргэжлийн хяналтын төвөөс сонгон шалгаруулдаг тэргүүлэгч эмнэлгээр жил дарааллан шалгарсан.
- Солонгосын Засгийн Газраас магадлан итгэмжлэгдсэн анхны эмнэлэг.
- 2013онд Солонгосын ерөнхийлөгчийн нэрэмжит ‘Тэргүүлэгч Эрүүл Мэндийн Байгууллага’ шагналаар шагнагдсан.



## Олон улсын анагаах ухааны хөгжлийг чиглүүлэн дэмжигч

- Арабын Нэгдсэн Эмират Улсын ‘Шейх Халифагийн нэрэмжит эмнэлэг’-ийн менежментийг хариуцан ажилладаг.
- Хятадын Янжи эмнэлэгт эмнэлгийн удирдлагын дотоод системийг нэвтрүүлэн, зөвлөх үүрэг гүйцэтгэдэг.
- Саудын Араб улсын зургаан том эмнэлэгт эмнэлгийн орчин үеийн дотоод сүлжээний мэдээлэл технологийн системийг нэвтрүүлэн хариуцан ажилладаг.
- Олон улсын эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилладаг.

# Эрүүл биед саруул ухаан оршино

## Сөүлийн Их Сургуулийн Эмнэлгийн Олон Улсын Эмчилгээний Төв

### Яагаад (Бидний онцлог)

1. Сөүлийн Их Сургуулийн Эмнэлгээр үйлчлүүлж буй гадаад иргэдэд түргэн шуурхай эмнэлгийн үйлчилгээг хүргэх.
2. Орчин үеийн шинжлэх ухаанд тулгуурласан баталгаат оношлогоо эмчилгээг нэг цэгээс авах.
3. Гадаадаас зорин ирж буй тухайн үйлчлүүлэгчийн шашин шүтлэг, соёлын онцлогийг харгалзан хүндэтгэн ажиллах.
4. Мэргэжлийн эмчээс цаашдын эмчилгээний төлөвлөгөөний талаарх урьдчилсан мэдээлэл авах
5. Англи, Хятад, Монгол, Орос, Испани, Япон зэрэг олон орны хэлээр эрүүл мэндийн мэргэжлийн орчуулгын үйлчилгээг хүргэх.

### Юу (Бидний үйлчилгээ)

- Жилд дунджаар 80 гаруй орны 30.000 гаруй гадаад иргэдэд эрүүл мэндийн эмчилгээ үйлчилгээ үзүүлдэг.
- Найрсаг, Хүнлэг, Итгэлт үйлчилгээг хүргэх.
- Олон улсын төлбөрийн картаар эмчилгээний төлбөр тооцоог хийх боломжтой.
- Гадаадаас хандсан үйлчлүүлэгчдэд мэргэжлийн тасгийн эмч эмчилгээний төлөвлөгөөтэй холбоотой хариу илгээх үйлчилгээг үзүүлэх боломжтой

- Үүнд:
- Архаг өвчтэй үйлчлүүлэгч тохирсон оношлогоо эмчилгээ хийлгэн, мэргэжлийн эмчийн байнгын хяналтанд орох боломжтой.
  - Мэргэжлийн эмчид хянуулж шаардагдах тохирсон шинжилгээ эмчилгээ болон зөвлөгөө авах боломжтой.
  - Олон улсын стандартын дагуу тохирсон вакцинжуулалтад хамрагдах боломжтой.




# Бид та бүхэнд үйлчлэхэд бэлэн байна

## Яаж (Хурдан шуурхай)

### Үйлчилгээний процесс

### Нэг-Цэгийн үйлчилгээ (Эмнэлгийн талаарх мэдээлэл, мэргэжлийн орчуулгын үйлчилгээ)



### Хилийн чандаас хандах дэс дараалал:



# Сөүлийн Их Сургуулийн Эмнэлгийн World-Class цогцолборууд

## Төв эмнэлэг

1. Мэдээгүйжүүлэлт, өвчин намдаах тасаг
2. Зүрх судасны төв
3. Арьс өнгөний тасаг
4. Түргэн тусламжийн тасаг
5. Өрхийн эмчилгээний тасаг
6. Мэс заслын тасаг
7. Дотрын тасаг
  - A. Харшил, Дархлаа судлалын тасаг
  - B. Зүрх судасны тасаг
  - C. Дотоод шүүрлийн тасаг
  - D. Хоол боловсруулах эрхтэний тасаг
  - E. Цусны эмгэг, цусны хавдрын тасаг
8. Мэдрэлийн тасаг
9. Сэтгэц мэдрэлийн тасаг
10. Мэдрэлийн мэс заслын тасаг
11. Цөмийн эмчилгээний тасаг
12. Эмэгтэйчүүдийн тасаг
13. Нүдний тасаг
14. Яс, үе мөч, гэмтэл согог заслын тасаг
15. Чих хамар хоолойн тасаг
16. Гоо засал, нөхөн сэргээх мэс заслын тасаг
17. Туяаны эмчилгээний тасаг
18. Нөхөн сэргээх физик эмчилгээний тасаг
19. Цээжний хөндий, зүрхний мэс заслын тасаг
20. Урологийн тасаг
21. Гамма-туяан эмчилгээний төв
22. Эрүүл мэндийн шинжилгээний төв
23. Эрхтэн шилжүүлэн суулгах төв
24. Паркинсоны төв

## Хавдрын эмнэлэг

1. Өсвөр насны хүүхдийн хавдрын төв
2. Тархины хавдрын төв
3. Хөхний хавдрын төв
4. Мөгөөрсөн хоолойн дурангийн төв
5. Цусны хорт хавдрын төв
6. Бүдүүн гэдэсний хавдрын төв
7. Мөчдийн болон сээр нурууны хавдрын төв
8. Ходоодны хавдрын төв
9. Хоол боловсруулах эрхтэний дурангийн төв
10. Эмэгтэйчүүдийн хавдрын төв
11. Нэгдсэн эмчилгээний төв
12. Элэгний хавдрын төв
13. Уушгины хавдрын төв
14. Химийн эмчилгээний төв
15. Нойр булчирхай, цөсний хавдрын төв
16. Туяа эмчилгээний төв
17. Арьсны хавдар / Арьсны химийн эмчилгээний төв
18. Нуруу нугасны хавдрын төв
19. Бамбай булчирхайн төв
20. Толгой хүзүүний хавдрын төв (Бамбай булчирхай, Амны хөндий, Толгой хүзүүний хавдар)
21. Урологи болон түрүү булчирхайн хавдрын төв

## Хүүхдийн Эмнэлэг

1. Хүүхдийн ерөнхий эмчилгээний тасаг
  - A. Нярайн тасаг
  - B. Хүүхдийн харшил, уушгины тасаг
  - C. Хүүхдийн зүрхний тасаг
  - D. Хүүхдийн эрчимт эмчилгээний тасаг
  - E. Хүүхдийн дотоод шүүрлийн тасаг
  - F. Хүүхдийн хоол боловсруулах болон хоол тэжээлийн тасаг
  - G. Хүүхдийн цусны хавдрын тасаг
  - H. Хүүхдийн дархлаа судлалын төв
  - I. Хүүхдийн халдвар судлалын төв
  - J. Хүүхдийн бөөрний тасаг
  - K. Хүүхдийн мэдрэлийн тасаг
2. Хүүхдийн сэтгэц мэдрэл сэтгэл зүйн тасаг
3. Хүүхдийн мэдээгүйжүүлэлт, өвчин намдаах тасаг
4. Хүүхдийн арьсны тасаг
5. Хүүхдийн мэдрэлийн мэс заслын тасаг
6. Хүүхдийн нүдний тасаг
7. Хүүхдийн яс үе мөч, гэмтэл согог заслын тасаг
8. Хүүхдийн чих хамар хоолойн тасаг
9. Хүүхдийн гоо засал, нөхөн сэргээх мэс заслын тасаг
10. Хүүхдийн нөхөн сэргээх физик эмчилгээний тасаг
11. Хүүхдийн мэс заслын тасаг
12. Хүүхдийн цээжний хөндий, зүрх судасны мэс заслын тасаг
13. Хүүхдийн урологийн тасаг
14. Хүүхдийн яаралтай түргэн тусламжийн тасаг
15. Сонсголын яс шилжүүлэн суулгах төв
16. Сэтгэц судлалын төв
17. Бөөрний төв
18. Өсвөр үе болон хүүхдийн хавдрын төв
19. Өсвөр насны хүүхдийн зүрхний төв
20. Хүүхдийн астма, харшлын төв
21. Хүүхдийн мэдрэлийн эмнэлзүйн төв
22. Ховор тохиолдох эмгэгт өвчний төв

